

ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ХҮҮХДИЙГ ТЭЖЭЭН ТЭТГЭХ ГЭРЭЭНИЙ ЗАРИМ АСУУДАЛ

THE CONCERN OF ALIMONY AGREEMENT IN FAMILY LAW

Даваахүүгийн Оюу*

Дотоод хэргийн их сургуулийн магистрант, хошууч

Maj. Oyu Davaakhuu, MA scholar, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: 209toirog@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүллээр гэр бүлийн харилцааны нэг болох тэжээн тэтгэх, тэтгүүлэх эрх, тэжээн тэтгэх гэрээг нарийвчлан судалж, тэжээн тэтгүүлэх эрх зүйн хэм хэмжээний зохицуулалт төдийгүй хэрэгжиж хэрэглэгдэж байгаа, цаашид анхаарах шаардлагатай зохицуулалтыг онцлон судаллаа. Монгол Улсын Үндсэн хуульд “гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх ашиг сонирхлыг төр хамгаална, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг” (Үндсэн хууль, 1992) гэж зохицуулсан зарчмын заалтаас улбаалан 1999 оны Гэр бүлийн тухай хуульд тэжээн тэтгэх, тэтгүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгсөн. Улмаар үр хүүхдээ тэжээн тэтгэх тэтгэлгийн хэлбэр, хэмжээ, хугацаа, тэтгэлэг төлөөгүйгээс гарах үр дагавар зэрэгтэй холбоотойгоор Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар нарийвчлан тусгаагүйгээс хүүхдийн эрх ашиг хөндөгдөж байна. Тэжээн тэтгэхтэй холбогдон үүсэж буй асуудлын шалтгаан үр дагаврыг нээн илрүүлэх, бусад улс орны эрх зүйн зохицуулалтын оновчтой шинэлэг зохицуулалттай харьцуулах замаар эцэг эх үр, хүүхдээ тэжээн тэтгэхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохыг зорилгоо.

Судалгааны ажлыг боловсруулахдаа гэр бүлийн эрх зүйн хамрах хүрээг “хүүхэд”-ийг тэжээн тэтгэхтэй холбоотой баримт бичигт дүн шинжилгээ хийж анализ, эмпирик, тоон болон харьцуулалтын аргуудыг ашигласан. Судалж байгаа сэдвийн талаар онол болон практикийн үүднээс харьцуулан дүгнэж хэрэгжилтэд нь тулгамдаж буй асуудлуудад дүн шинжилгээ хийж, эрх зүйн зохицуулалтын талаар саналаа дэвшүүллээ.

Abstract: This article is aimed at examining in detail the custody and maintenance rights and custody contracts that are part of the Family Relationship, highlighting not only the legal regulation of custody but also the regulations that are already in place and require further consideration. The 1999 Law on the Family provides for the legal regulation of Welfare and Maintenance activities in accordance with the provisions of the Constitution of Mongolia, which stipulates that the interests of the family, mothers, infants, and children are protected by the State and that the upbringing of children is the legal duty of every citizen. As a result, the best interests of the child are not fully reflected in the Child Protection Act, the Child Rights Act, and the Enforcement of Court Orders in relation to the type, amount, and duration of child support allowances, as well as the consequences of non-payment of child support benefits. The aim is to develop legal regulation related to parental and child support by uncovering causes and effects of problems related to nutrition and by comparing it with innovative legal regulations in



other countries. In order to develop the study, empirical, numerical, and comparative methods were used to analyze documents related to "child" support within the framework of family law. The topic of the study was compared on the basis of theory and practice, and the analysis of the issues facing its implementation has been done, and proposals for legal regulation has been put forward.

Түлхүүр үгс: Тэжээн тэтгэх, тэтгэлэг төлөгч, тэтгүүлэгч, амьжиргааны түвшин, тэтгэлгийн хэмжээ.

Keywords: Alimony, the payer grant, grantee, standard of living, amount of grant.

Удиртгал

Хүний эрх нь хувь хүний төрөлх мөн чанарыг агуулсан аливаа нэгэн төр шашны, хууль засаглалын ямар нэгэн тогтолцооноос олгодог буюу зөвшөөрдөг бус заяагдмал шинжтэй ойлголт юм.

Гэр бүлийн эрх зүйн хамрах асуудлын хүрээнд тэжээн тэтгэх, тэр дундаа хүүхдийг тэтгэхтэй холбогдсон харилцаа онцгой байр суурийг эзэлдэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.11-д “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх ашиг сонирхлыг төр хамгаална (Үндсэн хууль, 1992) гэж заажээ.

Тус заалтаас улбаалан 1999 оны Гэр бүлийн тухай хуульд Тэжээн тэтгэх, тэтгүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгсөн. Гэсэн хэдий ч тус хууль батлагдан гарснаас хойш өнөөдрийг хүртэл хүүхдийг болон гэр бүлийн гишүүд бие биеэ тэжээн тэтгэхтэй холбоотой дараах асуудлууд тулгамдсан хэвээр байна. Үүнд:

- хүүхдийн тэтгэлгийн хэмжээ хэтэрхий бага буюу хүүхдийн наад захын хэрэгцээнд хүрдэггүй;

- хүүхдийн тэтгэлгийг төлөхгүй байгаа тохиолдол жил ирэх тусам нэмэгдсэн;

- тэтгэлэг төлөгч төлбөрийн чадваргүй, оршин суух тодорхой хаяггүй, эрэн сурвалжлагдаж байгаа тохиолдол ихэссэн;

- хүүхдийн тэтгэлгийг хүүхдийн хэрэгцээнд зарцуулагдаж байгаа эсэх нь тодорхойгүй;

- тэжээн тэтгэх болон хөрөнгөтэй холбоотой гэрээ байгуулах асуудал дутмаг;

- зөвхөн шүүхийн журмаар албадлагын арга хэрэгслээр тэтгэлэг төлөгддөг;

- тэтгэлэг төлөгчид хүлээлгэх хариуцлагын механизм оновчгүй зэрэг болно.

Үндсэн хэсэг

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг Гэр бүлийн тухай хууль (Гэр бүлийн тухай хууль, 1999), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017)-ийг үндэслэн явуулж байна. Хүүхдийг тэжээн тэтгэх үүрэг нь хүүхдийг эрүүл орчинд өсөж хүмүүжихэд шаардлагатай хэрэгцээт наад захын зүйлсийг хангахад чиглэгддэг.

Хүүхдийн тэтгэлэг гэж хуульд заасан хэмжээ, хугацаагаар мөнгөн болон эд хөрөнгөөр гаргуулж, тэжээн тэтгүүлэгч хүүхдийн хэрэгцээнд зарцуулах хөрөнгийг хэлнэ. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа нь хэдийгээр иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэгэн адил явагдах боловч гэр бүлийн хүрээнд явагддаг өвөрмөц ажиллагаа юм.





ᠮᠤᠩᠭᠣᠯᠤ ᠰᠤᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

Гэр бүлийн тухай хуульд зааснаар эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй. Энэхүү үүргээ эцэг, эх нь харилцан тохиролцож гэрээ байгуулан шийдвэрлэж болохоор хуульд заасан ба хэрэв тэтгэлгийн хэмжээг харилцан тохиролцоогүй, тохиролцоонд хүрч чадаагүй, гэрээ байгуулаагүй тохиолдолд тэтгэлгийн хэмжээг хүүхдийн насны байдлыг харгалзан шүүх тогтоодог.

Хүүхдийн тэтгэлгийн мөнгийг тухайн тэжээн тэтгүүлэгч хүүхдийн оршин суугаа нутаг дэвсгэрт тогтоосон амьжиргааны доод түвшингийн тодорхой хувь хэмжээгээр тооцон төлбөр төлөгчөөс гаргуулан тэтгэлэг авагчид олгоно. Тэтгэлэг авагч хүүхэд гадаад улсад суугаа бол иргэний бүртгэлд бүртгэгдсэн болон сүүлд оршин сууж байсан бүс нутагт тогтоосон амьжиргааны доод түвшингийн тодорхой хувь хэмжээгээр тооцон олгодог. Шүүх хүүхдийн насыг харгалзан сард төлүүлэх тэтгэлгийг хэмжээг 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар, 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингийн 100 хувиар тооцон тогтоодог.

Нийслэлийн хэмжээнд 2024 онд хүүхдийн тэтгэлэг гаргуулах 15247 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулж байгаа боловч үүний цаана багаар бодоход 18 мянган хүүхдийн эрх зөрчигдөж байна. Тэтгэлэг авагч хүүхдийг насны байдлаар ангилан авч үзвэл 0-11 насны хүүхэд 14382 буюу 79.9 хувь, 11 ба түүнээс дээш насны хүүхэд 3617 буюу үлдсэн 21.1 хувийг эзэлж байна.

Улсын хэмжээнд 2024 оны 10 сарын байдлаар 11896 гэр бүл шинээр батлуулсан бол 3692 гэр бүл буюу 31 хувь нь гэр бүлээ цуцлуулсан байна (Улсын бүртгэлийн ерөнхий газар, 2024). Тэгвэл нийт шүүхээр гэр бүл цуцлуулсан хүүхдийн тэтгэлэг тогтоолгосон хэрэг маргааны 65.8 хувь буюу 1963 гүйцэтгэх баримт бичиг Шийдвэр гүйцэтгэх байгууллагад иржээ (ШШГЕГ, 2024).

Үүний 42,4 хувь буюу 833 гүйцэтгэх баримт бичиг нийслэлийн хэмжээнд хүүхдийн тэтгэлэг гаргуулах чиг үүрэг бүхий дагнасан нэгж болох Банкны төлбөр барагдуулах газарт шинээр ирсэн байна. Тус газар 2024 оны 10 дугаар сарын байдлаар хүүхдийн тэтгэлгийн 6466 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулж 426 гүйцэтгэх баримт бичгийг биелүүлж 6,5%-ийг хааж дуусгавар болгож 6040 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй ажиллаж байна (ШШГЕГ, 2024).

Тулгамдаж буй асуудал:

1. Тэжээн тэтгэх гэрээний талаарх ойлголт дутмаг, гэрлэгчид тэжээн тэтгэх гэрээг байгуулахгүй байгаагаас шалтгаалж гэр бүл салсны дараа үүсэх үр дагавар, цаг хугацаа, санхүүгийн асуудал нийгэмд тулгамдаж байгаа асуудлуудын нэгээр байсаар байна.

2. Тэжээн тэтгэх гэрээний харилцаанд оролцогч талуудын хэн ямар эрх эдэлж, үүрэг хүлээх талаарх зохицуулалт байхгүй.

3. Гэр бүлийн тухай хуулийн 40 дугаар зүйл “Тэтгэлгийн хэмжээ амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр гэж заасан байна. Энэ нь хуульд заагдсан амьжиргааны доод түвшин нь бүс нутгаараа өөр өөр байх бөгөөд бүс нутгийн үнэлгээгээр өнөөгийн нийгэм, зах зээлийн өсөлт түүнтэй адилтгах олон хүчин зүйлээс

шалтгаалж хүүхдийн наад захын хэрэгцээг бүрэн хангахад хүрэлцэхгүй байна.

4. Гэрлэлтийн гэрээний зарим асуудал нь Монгол Улсад төдийлөн хөгжөөгүй сэдэв бөгөөд Монголчууд гэрлэлтийн гэрээг зан заншил, ёс суртахуунтайгаа холбон гэрлэгчид гэрлэхдээ гэрээ байгуулах нь муу ёр,

салах гэж гэрлэж байгаа биш гэх мэт хандлага гарган гэрлэлтийн гэрээг байгуулдаггүй байна. Энэ нь гэрлэгчид салсны дараа үүсэх үр дагавар хүүхдийн тэтгэлэг болон гэрлэгчдийн хөрөнгийн эрхтэй холбоотой асуудлууд цаг хугацаа хөрөнгө мөнгөний асуудал үүсэх гол шалтгаан болж байна.

Эцэг эх, хүүхдээ тэжээн тэтгэх харилцааны зохицуулалтыг гэр бүлийн тухай хуулиудад хэрхэн тусгагдсан талаарх харьцуулалт				
№	Батлагдсан он, бүлэг, зүйл	Хуулийн зорилт	Эцэг эхийн хүлээх үүрэг	Хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой зохицуулалт
1	1926 оны Иргэний хууль нь 10 бүлэг 217 зүйлтэй ба Гэр бүлийн эрх, үүргийн тухай 6 анги 27 зүйлийг багтаасан байна.	Тус улсын дотор аливаа төрсөн, үрчилсэн, үхсэн ба эр, эм бололцсон, салсны тухай зэргийг нарийн нягт тодорхойлуулж, хойч өдөр байцаах тэмдэг болговоос зохих тул орон нутгийн захиргааны газрууд өрх амын дансанд оруулан тэмдэглэвээс зохимой гэснийг тайлбарлавал: Эр эм бололцох зэргийг тусгай тэмдэглэх явдлыг эдүгээ гүйцэтгэхийн уг бодлого болбоос хүмүүний завсартаа харилцах эрх үүргийг тодорхойлж эр эм, хүүхдийн эрх ашгийг тус тус хамгаалах хэргийг дөхмөөр явуулах бодлого	Эцэг эх болбоос өөрийн насанд хүрээгүй үр хүүхдээ сурган боловсруулах, алсдаа ард улсад тусгай хүмүүнийг бэлтгэх эрх ашгийг хамгаалах мөн болох тулд шүүх таслах буюу бусад газар аливаа хэргийн учир төлөөлбөөс зохимой. Эцэг эх нь хүүхдийнхээ сурч боловсрох эрх ашгийг нь хамгаалах үүрэгтэй төдийгүй энэ үүргийг хамтдаа гүйцэтгэх ёстойг зааж өгсөн.	Аливаа эхнэр хүүхэд төрүүлсний хойно түүний эцгийг нэр зааж илтгэсүгэй хэмээх авхуул шүүх таслах газраа мэдүүлэх бөгөөд тийнхүү нэр заасан эцэг болох хүмүүнээс хүүхдийг тэтгүүлэх ба тэжээх сурган хүмүүжүүлэх тухайн зарлага сүйтгэлийг гаргалцуулахаас гадна эхийн жирэмсэн явсан цагийн ба хүүхэд төрүүлсний хойно зургаан сарын хугацаанд амьдрал зэрэгт зарцуулсан ба зарцуулах зүйлийг мөн эцгээс гаргалцуулбаас зохимой гэжээ. (Мөнхжаргал, 1995, хууд. 87)
2	1956 оны Гэрлэх ба гэр бүл асрамж тэтгэмжийн хууль н 4 анги 116 зүйлтэй.	БНМАУ-ын ард иргэн гэрлэхдээ харилцан сэтгэлтэйгээ илэрхийлэн эрх тэгш, бие биеэ хүндэтгэн амьдралаа үүрд сайн дураараа нэгтгэн бие биеэ дэмжин нийгмийн амьдралд идэвхтэй	Эцэг эх нь насанд хүрээгүй хүүхдийнхээ эрүүл мэнд, биений бойжилт зөв хүмүүжлийн төлөө санаачлах ба түүнийг сургах, нийгэмлэгт ашиг тустай ажил хийх явдалд бэлтгэх үүрэгтэй. Үр хүүхдэд	Хүүхдийн тэтгэвэр олгохдоо насанд хүрээгүй нэг хүүхдэд хариуцагчийн сар тутмын орлогын 25 хувийг, хоёр хүүхдэд 35 хувийг гурав ба түүнээс дээш хүүхдэд бол 50 хувиар бодож





ᠬᠤᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ
ᠰᠠᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

		оролцох, гэр бүл болж эрэгтэй эмэгтэй зөвхөн 2 хүний ханилан суух зарчмыг баримталж түүнчлэн гэрлэгсэд тэдний үр хүүхдийн амин хувийн ба эд хөрөнгийн эрх, ашгийг хамгаалах зорилгоор гэрлэснээ иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх газар заавал бүртгүүлэх ёстой. (Мөнхжаргал, 1995, хууд. 87)	холбогдсон бүхий ларга хэмжээг эцэг эх хоёроос хамтран гүйцэтгэвэл зохино.	гаргуулбал зохино. Биеийн хүчээ үнэлдэггүй хүмүүсээс тэтгэвэр гаргуулахдаа жилийн бүх орлогоос нь энэ зүйлд заасан хувиар бодож гаргуулна. Хөдөлмөрийн чадваргүй, гачигдаж байгаа, насанд хүрсэн хүүхдэд эцэг эхээс нь тэтгэвэр гаргуулахдаа тэтгэх хөрөнгийн хэмжээг эд хөрөнгийн байдлыг харгалзан шүүх тогтоовол зохино гэж заажээ.
3	1973 оны Гэр бүлийн хууль нь 5 хэсэг 13 бүлэг, 113 зүйлтэй. 3	Коммунист ёс суртахууны зарчмаар үүссэн гэр бүлийг дэмжин бэхжүүлэх эцэг эх, үр хүүхэд болон гэр бүлийн бусад гишүүний эрх ашгийг хамгаалах, гэрлэгсдийн нийгэмд гүйцэтгэх үүрэг хариуцлагыг дээшлүүлэн гэр бүл, гэр ахуйн харилцаанд үлдсэн аливаа хоцрогдмол дадал заншлыг арилгахад оршино.	Хууль ёсоор тогтоосон эцэг эх, хүүхдийн хооронд энэ хуульд заасан эрх, үүрэг үүснэ. Эцэг эх нь хүүхдээ асран хамгаалж Тэжээн, тэтгэж, өсгөн хүмүүжүүлэх үүрэгтэй. Эцэг эх гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд энэ үүрэг хэвээр хадгалагдана. Насанд хүрээгүй хүүдийн хууль ёсны төлөөлөгчийн хувьд эцэг, эх хүүхдийнхээ эрх ашгийг шүүх болон улс олон нийтийн бусад байгууллагын өмнө хариуцан хамгаална.	Насанд хүрээгүй хүүхдэд тэжээн тэтгүүлэх, тэтгэвэр гаргуулахдаа шүүх тэтгэвэр авах хүүхдийн тоо, хариуцагч болон хүүхэд гардан хүмүүжүүлэгчийн орлого, аж ахуйн чадвар, хөдөлмөрийн чадваргүй хүмүүсийн тоог харгалзан хариуцагчийн сар бүрийн цалингаас /орлого/ нэг хүүхдэд 15- 25 хувь хүртэл, хоёр хүүхдэд 35 хувь хүртэл, гурав буюу түүнээс дээш тооны хүүхдэд 50 хувь хүртэл хэмжээгээр тогтооно. Тэжээн тэтгэх тэтгэврийг гагцхүү хүүхдийн хэрэгцээнд зарцуулна.
4	1999.06.11-ний өдөр батлагдсан Гэр бүлийн тухай хууль нь 9 бүлэг 76 зүйлтэй.	Хуулийн зорилт нь гэрлэх нөхцөл журам, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бүс	Эцэг эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй. Эцэг эх	Хүүхдийн тэтгэлгийг 11 нас хүртэлх хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50

	гэж тооцох, түүний үр дагавар, эцэг эх, хүүхдийн хоорондын харилцаа, тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцаа, хүүхэд үрчлэх, Асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	харилцан тохиролцож чадаагүй бол шүүх тэтгэлийг тогтооно.	хувиар, 11-16 нас /суралцаж байгаа бол 18тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй/ хүүхдэд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр зөвхөн цалин хөлснөөс өөр орлогогүй хариуцагчаас гаргуулах хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь түүний сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 50 хувиас хэтэрч болохгүй тэтгэлгийг мөнгөн хэлбэрээр, эд хөрөнгөөр олгоно. Тэтгэлгийг сар улирал, хагас жил, жилээр нэг удаа олгоно.
--	--	---	--

Хүснэгт №1. Эцэг эх, хүүхдээ тэжээн тэтгэх харилцааны зохицуулалтыг гэр бүлийн тухай хуулиудад хэрхэн тусгагдсан талаарх харьцуулалт

ОХУ-ын тэжээн тэтгэх гэрээний эрх зүйн зохицуулалт

ОХУ-ын Гэр бүлийн тухай хуульд энэ төрлийн гэрээг "Заключение соглашения об уплате алиментов" буюу тэтгэмж төлөх тухай гэрээ байгуулах гэж нэрлэн хуульчилж өгсөн байна. Энэхүү гэрээний зохицуулалт нь манай улсын тэжээн тэтгэх тухай гэрээтэй агуулгын хувьд адил төстэй байх тул цаашид "тэжээн тэтгэх гэрээ" гэх нэр томъёогоор бичдэг болно.

ОХУ-ын Гэр бүлийн хуулиар тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцааг тэтгэмж төлөгч болон тэтгэмж авагч гэрээ байгуулан тохиролцох, гэрээ байгуулаагүй тохиолдолд тэтгэмжийг шүүхийн журмаар суутгуулж болдог (Федерации г. к., 2024).

Тус улсын Гэр бүлийн хуульд зааснаар тэжээн тэтгэх гэрээ гэдэгт тэтгэлэг хүлээн авагчийн хооронд

тэтгэмж төлөх нөхцөл, журам, хэмжээг харилцан тохиролцон байгуулсан гэрээ (Федерации С. к., 2024)-г хэлнэ гэжээ.

ОХУ-ын Гэр бүлийн хуулийн 100.1 дэх хэсэгт зааснаар тэжээн тэтгэх гэрээг бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлсэн байх шаардлага тавигддаг ба тус хуулийн шаардлагыг хангаагүй гэрээ нь хүчин төгөлдөр бус байна. (Уянга, 2024) Гэрээ байгуулах журмын талаарх хуулийн энэ зохицуулалт нь манай улсын гэр бүлийн хуулийн заалттай нэгэн адил байна.

Гэрээний талууд гэрээний нөхцөлийг өөрчлөх, эсвэл цуцлах талаар тохиролцож чадахгүй бол сонирхсон тал нь үүнийг шүүхэд хандан гэрээг цуцлах асуудлыг шийдвэрлүүлэх эрхтэй (Уянга, 2024).

Насанд хүрээгүй хүүхдэд болон гэр бүлийн эрх зүйн чадамжтай гишүүнд тэтгэмж төлөхөөр тохиролцсон тэжээн тэтгэх гэрээ



МОНГОЛЫН ХҮҮЛЬ



хүчингүй болгоход нэмэлт тусгай нөхцөлүүдийг оруулж ирдэг. Хэрэв эдгээр хүмүүсийн эрх ашиг бодитоор зөрчигдсөн байвал гэрээг шүүхийн журмаар хүчингүйд тооцдог (Уянга, 2024). Бодит байдлаар зөрчигдөх гэдэгт хамгийн түрүүнд тэтгэмжийн хэмжээг хэт багасгасныг ойлгоно. Хэрэв тухайн иргэн хуулийн дагуу авах ёстой хэмжээнээс харьцангуй бага хэмжээгээр тэтгэмж авч байвал гэрээг хүчин төгөлдөр бусд тооцно.

Тэтгэмж төлөх журам, арга хэлбэрийг талууд өөрсдийн үзэмжээр харилцан тохиролцох боломжтой ба энэ талаар хуульд хязгаарлалт хийгээгүй онцлогтой байна. Хууль тогтоогчид ерөнхийдөө дараах байдлаар төлөхийг хүлээн зөвшөөрдөг байна. Үүнд:

- Цалин хөлсний хувь хэмжээ (бусад орлого);
- Тогтмол хэмжээгээр нэгэн зэрэг юм уу хэсэгчилсэн байдлаар;
- Эд хөрөнгө өгөх байдлаар;
- Талуудын тохиролцсон бусад арга замаар түүнчлэн янз бүрийн арга замын холимог хэлбэрээр зэрэг тус тус хамаарна (Уянга, 2024).

Төлөх журмын хувьд тэтгэмжийг биечлэн хүлээлгэн өгөх, гуравдагч этгээдээр дамжуулан тэтгэмж авагчийн дансанд шилжүүлэх гэх мэт арга хэлбэрүүд байж болдог аж. Тэтгэмж төлөх арга, хэлбэрийг талуудад өөрсдөө сонгох боломжтой байгаа нь манай улстай адил байна.

ОХУ-ын нэгэн онцлог зохицуулалт нь тэжээн тэтгэх гэрээгээр төлөх тэтгэмжийн хэмжээг индексжүүлэхтэй холбоотой заалт юм. Тэтгэмжийн хэмжээг индексжүүлэх талаарх ойлголт нь зөвхөн тогтмол мөнгөн дүнгээр тэтгэмж төлөхөд хамаарна. Энэхүү заалтын ач холбогдол нь цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод хувиар ногдуулах тэтгэмж нь

олох орлого нэмэгдэхийн хэрээр нэмэгддэг учир тэтгүүлэгчид давуу байдлыг олгож байгаад оршино.

Гэрээний үүрэг дуусгавар болох нөхцөлийн хувьд: Нотариатаар баталгаажуулсан тэжээн тэтгэх гэрээний дагуу тэтгэмж төлж байгаа бол гэрээний хугацаа дуусахад эсхүл гэрээнд заагдсан бусад үндэслэлээр тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болно.

ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт

ХБНГУ-ын хувьд тэжээн тэтгэх гэрээтэй холбоотой зохицуулалтыг Иргэний хуулийн 1585-1585 дахь зүйлүүдэд /Gestaltung des Unterhaltsanspruchs буюу тэжээн тэтгэх шаардлагыг гэрээгээр тодорхойлох/ тусган хуульчилсан байна (Уянга, 2024).

Тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцааг гэрээгээр тодорхойлох боломжтой бөгөөд энэ нь зөвхөн гэрлэгчдийн хоорондох харилцаанд хэрэгжихээр байна.

Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулсны дараа тэтгэмж, төлөх үүрэг хүлээх тухай гэрээгээр тохиролцож болох ба уг тохиролцоог гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулж, нотариатаар гэрчлүүлэх шаардлагатай. Гэр бүлийн хэрэг хянан хэлэлцэх шүүхийн өмнө тэмдэглэл хөтлөх тохиолдолд нотариатаар гэрчлүүлэх хэлбэрийн шаардлагыг “Иргэний Процессын хуулийн дагуу үйлдсэн протоколоор орлуулж болох”-оор Иргэний хуульд тусгасан нь манай улсаас онцлог зохицуулалт байна. Өөрөөр хэлбэл, шүүхийн протокол буюу шүүх хуралдааны тэмдэглэлд талууд тэжээн тэтгэхтэй холбоотой асуудлыг гэрээгээр тохиролцсон талаар тусгагдсан тохиолдолд энэ нь нотариатаар гэрчлүүлсний нэгэн адил хуулийн хүчинтэй байна.



Манай улсын хувьд гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулах нэхэмжлэлтэй хамтад нь тэжээн тэтгэхтэй холбоотой асуудлыг хянан шийдвэрлүүлэх сонирхол ихээхэн байдаг бөгөөд гэрлэгчид тэжээн тэтгэх талаарх гэрээ байгуулсан тохиолдол маш бага байсан тухай миний бие тэжээн тэтгэх гэрээтэй холбоотой судалгаандаа дурдсан болно.

Хэдий нарийн тоо баримтыг гарган тэмдэглэж аваагүй ч гэсэн шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй гэрлэлт цуцлах тухай хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааны явцад хүүхдийн тэтгэмжийн хувь хэмжээг харилцан тохиролцох байдлаар тогтоосон тохиолдлууд шүүх хуралдааны тэмдэглэлд нэлээдгүй тэмдэглэгдсэн байсан юм. Эдгээр тохиролцоог тэжээн тэтгэх гэрээ байгуулсан гэж үзэж болох үндэслэлийг тус улсын хуульд тусгаж өгсөн нь онцлог байна.

Тэтгэмж олгох хэлбэрийг тогтмол олгох тэтгэмж болон нэг удаагийн хөрөнгө оруулалтын хэлбэр гэж 2 ангилна. Нэг удаагийн хөрөнгө оруулалтын хэлбэрийг хүндэтгэн үзэх шалтгаан бий бөгөөд үүрэг гүйцэтгэгчийн эрхийг хэт хязгаарлаагүй тохиолдолд сонгох боломжтой байхаар хуульд заажээ (Уянга, 2024).

Энэхүү тэтгэмж шаардах эрх нь тэтгэмж авч буй тал нь ахин гэрлэсэн, хамтын амьдрал үүсгэсэн эсвэл нас барсан тохиолдолд дуусгавар болно. Харин тэтгэмж төлөгч тал нь нас барсан тохиолдолд түүний эрх залгамжлагч нь тэжээн тэтгэх гэрээгээр хүлээсэн үүргийг үргэлжлүүлэн биелүүлэх боломжтой байхаар хуульчлан зохицуулсан нь бусад улсын зохицуулалтаас ихээхэн онцлог байна.

Дүгнэлт

Тэжээн тэтгэх тухай гэрээний онцлог нь тэжээгчээс тэтгүүлэгчид материаллаг тусламж үзүүлэхэд оршиж байна. Монгол улсын Гэр бүлийн тухай хуулийн энэ талаарх зохицуулалтыг гадаад улсуудын хуулийн тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжуудтай харьцуулан үзэхэд гэрээг байгуулах журам, гэрээний талууд гэрээний зүйл гэрээг өөрчлөх, цуцлах үндэслэл журам зэрэг нь нийтлэг байдлаар зохицуулагджээ.

Дээрхээс үзэхэд тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцааг гэрээгээр зохицуулах эрх тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцааг гэрээгээр зохицуулах эрх бүхий субъект зөвхөн гэрлэгчид байх бөгөөд тэдгээр бусад гэр бүлийн гишүүдийн тэжээн тэтгэхтэй холбогдох харилцааг хуулиар зохицуулсан тэтгэмж шаардах эрх, тэжээн тэтгэх үүргийн харилцааг хуульчилсан зүйл заалтуудын дагуу шийдвэрлэхээр байгаа нь манай улс болон ОХУ-ын эрх зүйн зохицуулалтаас онцлог байна.

Манай улсын хувьд тэжээн тэтгэх гэрээгээр тохиролцох тэтгэлгийн доод хэмжээг хуулиар тогтоож өгсөн ба тус гэрээгээр тохиролцох тэтгэлгийн хэмжээ нь уг хуулиар заасан хэмжээнээс доогуур байхыг хориглосон нь ОХУ-ын тэжээн тэтгэх тэтгэлгийн хэмжээг тогтоох журмаас ялгагдах онцлогтой байна. Харин тэтгэлэг төлөгчийн орлого өсөхийн хэрээр тэтгэлэг авагчид олгох тэтгэлгийн хэмжээ нэмэгдэж, тэтгэлэг төлөгчийн орлого бага тохиолдолд түүнтэй хувь тэнцүүлэн тэтгэлгийн хэмжээг бууруулан тооцох аргачлалыг тэтгэлгийн хэмжээг индексжүүлэх гэх ухагдахуунаар тодорхойлон томьёолох бөгөөд энэ нь тэтгэмж төлөгчийн санхүүгийн боломж, тэтгэмж авагчийн эрх ашгийг тэнцвэртэй байдлаар авч



ᠮᠤᠩᠭᠠᠢ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

үздэг ихээхэн ач холбогдолтой ойлголт юм.

Манай улсын хувьд тэтгэлгийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй харьцуулахад харьцангуй бага, амьжиргааны доод түвшингээс тогтоосон хувь хэмжээгээр тэтгэлгийг тооцоход тэтгүүлэгчийн зайлшгүй шаардлагатай хэрэгцээг бүрэн хангахад хүрэлцэхгүй хэмжээний тэтгэлэг байх тохиолдолд амьжиргааны баталгаажих доод түвшингээс хувь тэнцүүлэх бус харин тэтгэгчийн цалин орлогоос хувь тэнцүүлэн тэтгэлгийн хэмжээг тооцдог ОХУ-ын жишгийг харгалзаж талууд гэрээгээ байгуулах боломжийг хуулиар тогтоож өгөх нь нэг талаас өндөр орлоготой тэтгэлэг төлөгчийн орлогоос хувь тэнцүүлэн тэтгэлгийг төлүүлэх нь тэтгүүлэгчийн эрх ашигт илүү нийцнэ. Нөгөөтээгүүр орлого багатай тэтгэлэг төлөгч нь хуулиар заасан хувь хэмжээгээр тэтгэлэг төлөхөд түүнд санхүүгийн бэрхшээл үүсэхийг үгүйсгэх аргагүй бөгөөд энэ тохиолдолд орлогоос хувь тэнцүүлэн тэтгэлгийг гаргуулах нь тэтгэлэг төлөгчийн эрх ашигт нийцэж гэрээний талуудын аль алины эрх ашгийг тэнцвэртэй хангахад чиглэгдэнэ гэж үзэж байна.

ХБНГУ-ын хувьд тэтгэмж шаардах эрх нь тэтгэмж авч буй тал нь ахин гэрлэсэн, хамтын амьдрал үүсгэсэн эсвэл нас барсан тохиолдолд дуусгавар болно. Харин тэтгэмж төлөгч тал нь нас барсан тохиолдолд түүний эрх залгамжлагч нь тэжээн тэтгэх гэрээгээр хүлээсэн үүргийг үргэлжлүүлэн биелүүлэх боломжтой байхаар хуульчлан зохицуулсан нь бусад улсын зохицуулалтаас ихээхэн онцлогтой байна.

Манай улсад тэжээн тэтгэх гэрээний хэрэгжилт хангалтгүй байгаа нь судалгаанаас харагддаг. Энэ нь тэжээн тэтгэх гэрээний талаарх ойлголт

сул, гэрээгээр тэжээн тэтгэх харилцааг зохицуулахын онцлог, ач холбогдлыг бүрэн таньж мэдэхгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

Гэр бүлийн эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тэр дундаа гэрлэлтийн гэрээ байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, гэрлэгчдийн эрх, ашгийг хамгаалахад бодитой хувь нэмэр оруулах нь төр, засгийн анхаарвал зохих асуудал болж байна.

Гэрлэгчид эд хөрөнгийн эрхээ зохицуулах боломжтой гэрээ нь эд хөрөнгийн Гэрлэгчид гэрлэлтийн гэрээний ач холбогдлыг төдийлөн ойшоохгүй практикт хэрэглэгдэхгүй байна. Иймд гэрлэгчид гэр бүл болохоор бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхээр очихдоо гэрлэлтийн гэрээг заавал хийсэн байхаар хуульчилж өгвөл зохилтой байна.

Санал

Судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1.Тэжээн тэтгэх гэрээг асрамжийн газарт байгаа ахмад настай иргэд хүүхэд нь байгаа бол хүүхэдтэйгээ заавал уг гэрээг байгуулдаг байх. Уг тэжээн тэтгэх гэрээг талууд Гэр бүлийн тухай хуулийн 45.1 дэх хэсэгт зааснаар гэрээг бичгээр үйлдэж, нотариатаар гэрчлүүлсэн байна.

2.Тухайн гэр бүлд ноогдох нийт орлогын хэмжээ 5 саяас дээш бол тэтгэлгийн хэмжээг гэрээгээр тохиролцож тогтоодог болох. Уг тэтгэлгийн доод хэмжээг Гэр бүлийн тухай хуулийн 40.1.2 хэсэгт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэж тусгах.

3.Гэрлэгчид гэрлэлтийн гэрээг заавал байгуулдаг байх. Энэ нь Иргэний хуулийн 125 дугаар зүйлд заасан гэр бүлийн хөрөнгийн эрхтэй холбоотой харилцааг зохицуулахад

чиглэгдэнэ. Гол нөхцөлд: Хамтран өмчлөх дундын өмч, дундаа хэсгээр өмчлөх хөрөнгө, хуваарьт хөрөнгийг гол нөхцөлөөр тусгаж нэмэлтээр гэрлэгчид ирээдүйд бий болох хөрөнгө зэргийг гэрлэлтийн гэрээгээр зохицуулдаг болох нэмэлт заалт тусгаж өгөх зэрэг болно.

Ашигласан эх сурвалж

Гэр бүлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №30 (Улсын их хурал 1999).

Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №1 (Улсын их хурал 1992).

Мөнхжаргал, Т. (1995). *Гэр бүлийн эрх зүй*. Улаанбаатар.

Улсын бүртгэлийн ерөнхий газар. (2024 оны 10 02). *Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны 09-р сарын тоон мэдээ*. burtgel.gov.mn: <http://burtgel.gov.mn/post/66169-ээс> Гаргасан

Уянга, Б. (2024 оны 10 20). *Гэр бүлийн эрх зүй дэх гэрээ*. legaldata: <http://legaldata.mn/b/303-ээс> Гаргасан

Федерации, г. к. (2024 оны 10 20). *Консультант Плюс*.
Консультант Плюс:
[consultant.ru/document/cons_doc_LAW_5142/?esclid=m2sezlyy1t455207445](https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_5142/?esclid=m2sezlyy1t455207445)-ээс Гаргасан

Федерации, С. к. (2024 оны 10 20). *Консультант Плюс*.
Консультант Плюс:
https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_8982/?esclid=m2sf0xqqvs360940399-ээс Гаргасан

Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль. (1998). *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, №2.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №24 (Улсын их хурал 2017).

ШШГЕГ. (2024). *2024 оны 10 сарын мэдээ*. УБ,: Шийдвэр гүйцэтгэх алба.

ШШГЕГ. (2024). *ШШГЕГ-ын 2024 оны 10 мэдээ*. УБ,: Банкны төлбөр барагдуулах газар.



Дорноговь аймгийн
Хүн амын амьжиргааны
доод түвшинг тодорхойлох
тухай хууль